

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
ЗАХИРАЛ ~~Б.Х.Н. ЛХАГВАДОРЖ~~  
2024 оны 5 сарын 10 өдөр  
БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛЬ  
БСВ

**2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН  
10 ДУГААР АНГИД СУРАГЧ ЭЛСҮҮЛЭХ УДИРДАМЖ**

**ЗОРИЛГО:** Өөрийн суралцах зорилгыг Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургууль (ЕБШМС)-ийн бодлого, зорилготой нэгтгэн, сорилтыг даван туулж, амжилтад хүрэх хүсэл, эрмэлзэлтэй сурагчдад боломж олгох үүднээс 10 дугаар ангийн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

**ЭЛСЭХ СУРАГЧДАД ТАВИХ ШААРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОО:**

2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-ийн 9 дүгээр ангийг төгсөж, суурь боловсрол эзэмшигчдээс **20** сурагч элсүүлж, 2024-2025 оны хичээлийн жилд ЕБШМС-ийн 10 дугаар ангид суралцуулна.

**ЭЛСЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ:**

Элсэлтийн шалгалтын үр дүнгээр хяналтын тоонд багтаж, 10-р ангид суралцах болзол хангасан сурагчид дараах төрлийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлнэ. Үүнд:

1. Математик, хими, физик, биологийн судлагдахууны аль нэгээр **УЛСЫН** төрөлжсөн олимпиадын медальт байрын шагналтай бол 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрөөс **100 хувийн хөнгөлөлт**;
2. Математик, хими, физик, биологийн судлагдахууны аль нэгээр **АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН** төрөлжсөн олимпиадын медальт байрын шагналтай бол 2024-2025 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн **50 хувийн хөнгөлөлт**;

**ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ**

№	Зохион байгуулалт	Хугацаа	Хэлбэр
1	Зар мэдээллийг олон нийтэд хүргэх	5 сарын 10-наас	цахим сувгаар
2	Элсэхийг хүсэгчдийг бүртгэх	6 сарын 3-наас 6 сарын 12	цахимаар
3	Бичгийн шалгалт зохион байгуулах	6 сарын 15	танхимаар
4	Бичгийн шалгалтын дүн гаргах, шалгуулагчдад мэдээлэл хүргэх	6 сарын 15	цахимаар
5	Бичгийн шалгалтад тэнцсэн сурагчдаас ярилцлагын шалгалт авах	6 сарын 16	танхимаар
6	Ярилцлагын шалгалтын дүн гаргаж, тэнцсэн сурагчдад мэдээлэл хүргэх	6 сарын 16	цахимаар
7	Элсэх болзол хангасан сурагчдад батламж гардуулах	6 сарын 17	биечлэн
8	Элсэх болзол хангасан сурагчдын эцэг эхтэй гэрээ байгуулах	6 сарын 17-21	биечлэн

**ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ:**

1. Элсэхийг хүсэгчдийг 2024 оны 06 сарын 03-ны өдрийн 16:00 цагаас 06 сарын 12-ны өдрийн 16:00 цагийг дуустал <http://202.21.114.244/shinemongol-10/> цахим хаягаар бүртгэж, бүртгэлийн дугаар олгох ба бүртгүүлэгч нь регистрийн дугаараар цахим бүртгэлд зөвхөн нэг удаа хандах боломжтой.
2. Элсэхийг хүсэгч нь доорх асуулт тус бүрд дэлгэрэнгүй хариулж, **word** эсхүл **pdf** файлаар бүртгэлийн системд оруулна. Асуултын хариултыг оноогоор дүгнэхгүй ба хүүхдийн хүсэл, эрмэлзлийг тодруулах үүднээс хүлээн авна.

**Асуулт:**

1. *Чиний хүсэл, мөрөөдөл, зорилго юу вэ? Чи зорилгынхоо төлөө юу хийдэг вэ?*

2. Чиний давуу болон сул тал юу вэ? Өөрийн давуу болон сул талаасаа шалтгаалж, амжилт эсвэл бүтэлгүйтэлд орж байсан тохиолдлоо хуваалцана уу?
  3. Чи хамгийн сүүлд уншсан номоо нэрлэнэ үү. Яагаад тухайн номыг унших болсон бэ? Тухайн номоос юуг ойлгож авсан бэ?
  4. Чи Шинэ Монгол сургуулийн юуг нь онцолж, сонгох болсон бэ?
  5. Сурлага, урлаг, спортын чиглэлээр **ЗӨВХӨН** 9-р ангид гаргасан амжилтаа бичээрэй.
3. Бүртгүүлэгчийн овог нэр, регистрийн дугаарыг кирил үсгээр алдаагүй бичнэ.
  4. Бүртгүүлэгчийн цээж зургаа JPEG, PNG, JPG өргөтгөлөөр оруулах бөгөөд зурган файлыг сурагчийн нэрээр нэрлэсэн байна.
  5. Бүртгэлийн хураамж 40,000 төгрөгийг <http://202.21.114.244/shinemongol-10/> хаягаар орж, QRAY үйлчилгээг ашиглан, QR код уншуулан төлнө.
  6. Бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг бүртгүүлсэн e-mail хаягаар илгээх тул **тогтмол ашигладаг e-mail хаяг, холбоо барих утасны дугаарыг заавал** бичнэ.
  7. Бүртгэл амжилттай болсноор бүртгүүлэгч цахим бүртгэлийн системд нэвтрэх эрхтэй болох бөгөөд 2024 оны 06 сарын 14-ний өдрийн 16:00 цагт бүртгэлийн системд шалгалт өгөх анги, суудлын дугаар тавигдсан байна.

#### **ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН АГУУЛГА, ХЭЛБЭР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

1. Шалгалт нь БШУЯ-наас баталсан суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн үндсэн агуулгын хүрээнд байна.\*
2. Элсэлтийн шалгалтыг бичгийн болон ярилцлагын хэлбэрээр **танхимаар** зохион байгуулна.
3. Шалгалтын нийт дүнгийн 80 хувийг бичгийн шалгалтаар, 20 хувийг ярилцлагын шалгалтаар тооцно.
4. Бичгийн шалгалтыг 150 минутын хугацаанд дараах 5 хичээлийн нэгдмэл агуулгаар авч, оноожуулна. Үүнд:
  - а. Математик 40 оноо
  - б. Монгол хэл 15 оноо
  - с. Англи хэл 15 оноо
  - д. Хими 15 оноо
  - е. Физик 15 оноо
5. Бичгийн шалгалтын гүйцэтгэлийн хувиар эхний 30 сурагчидтай ярилцлагын шалгалт зохион байгуулна.
6. Шалгалтад ирэхдээ бүртгэлийн системээс **бүртгэлийн хуудсаа хэвлэж авчрах** ба шалгалт эхлэхээс **10 минутын өмнө шалгалт өгөх** ангид ирсэн байна.

#### **ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫН ХУГАЦАА:**

1. Бичгийн шалгалтыг 2024 оны 06 сарын 15-нд 10:00-12:30 цагийн хооронд зохион байгуулна.
2. Бичгийн шалгалтын гүйцэтгэлийн хувиар эхний 30 сурагчидтай 2024 оны 06 сарын 16-нд 09:00-13:00 цагийн хооронд ярилцлагын шалгалт зохион байгуулна. Ярилцлагын шалгалтын хуваарийг цахим бүртгэлийн систем болон e-mail хаягаар илгээнэ.

#### **ДҮН МЭДЭЭ:**

1. Бичгийн шалгалтын дүнг 2024 оны 06 сарын 15-ны 19:00 цагт багтаан бүртгэлийн дугаараар нь "Шинэ Монгол сургууль" фэйсбүүк хуудас болон цахим бүртгэлийн системээр мэдээлнэ.
2. Ярилцлагын шалгалтын дүнг 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 16:00 цагт багтаан цахим бүртгэлийн систем болон бүртгүүлсэн e-mail хаягаар илгээнэ.
3. Элсэлтийн шалгалтад тэнцсэн сурагчид эцэг эхийн хамт 2024 оны 06 сарын 17-ны өдөр элсэн суралцах батламжийг сургуулийн захирлаас гардан авна. Батламж олгох цагийн хуваарийг цахим бүртгэлийн системд байршуулна.

**ХОЛБОО БАРИХ:** Сургуулийн утас 7777-5599  
Элсэлттэй холбоотой асуултыг 80287052  
Цахим бүртгэлтэй холбоотой асуултыг 80280591  
Элсэлтийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, өргөдлийг  
[school@shinemongol.edu.mn](mailto:school@shinemongol.edu.mn) хаягаар тус тус хүлээж авна.